

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.НЯМЖАВ ТАНАА

2026.02.24 № УВА-2026/102/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8526050100

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	532,151,201.79	357,142,669.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	333,744,886.55	153,968,118.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	333,744,886.55	153,968,118.03
3121	Төгрөг	333,744,886.55	153,968,118.03
31211	Төрийн сангийн харилцах	333,744,886.55	153,968,118.03
33	АВЛАГА	6,400,000.00	00.00
335	Бусад авлага	6,400,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	6,400,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	192,006,315.24	203,174,551.42
354	Хангамжийн материал	192,006,315.24	203,174,551.42
35410	Бичиг хэргийн материал	931,602.24	931,602.24
35420	Аж ахуйн материал	164,410,743.00	171,749,189.78
35440	Түлш, шатах тослох материал	1,250,000.00	1,250,000.00
35460	Хүнсний материал	11,271,580.00	10,212,470.00
35470	Бусад хангамжийн материал	14,142,390.00	19,031,289.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,101,345,453.01	5,026,007,257.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,101,345,453.01	5,026,007,257.71
392	Биет хөрөнгө	5,007,825,453.01	4,932,487,257.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,688,454,480.00	5,753,254,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-999,646,505.61	-1,137,204,468.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,700,000.00	29,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,706,250.00	-20,418,750.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	563,993,732.80	481,936,301.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-367,420,014.31	-293,502,262.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	230,497,045.78	220,730,403.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-160,406,971.83	-141,368,383.49
39217	Ном	39,359,936.18	39,359,936.18
393	Биет бус хөрөнгө	93,520,000.00	93,520,000.00
39301	Программ хангамж	800,000.00	800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-800,000.00	-800,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	93,520,000.00	93,520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,633,496,654.80	5,383,149,927.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	72,588,899.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	72,588,899.38
413	Өглөг	00.00	72,588,899.38
4136	Бусад өглөг	00.00	72,588,899.38
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	72,588,899.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,633,496,654.80	5,310,561,027.78
51	Засгийн газрын хувь оролцоо	5,633,496,654.80	5,310,561,027.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	905,057,582.98	905,057,582.98
51101	Өмч: - төрийн	905,057,582.98	905,057,582.98
512	Хуримтлагдсан үр дүн	4,511,315,275.77	4,188,379,648.75
51210	Өмнөх үеийн үр дүн	4,511,315,275.77	4,511,315,275.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-322,935,627.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,123,796.05	217,123,796.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,633,496,654.80	5,383,149,927.16



2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,396,205,715.00	3,523,186,675.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,855,515.00	130,053,975.18
120	Нийтлэг татварын бус орлого	127,855,515.00	130,053,975.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	697,200.00	4,209,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	697,200.00	4,209,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,268,350,200.00	3,393,132,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,865,163,600.00	3,060,372,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,865,163,600.00	3,060,372,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	239,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	239,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	403,186,600.00	332,521,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	403,186,600.00	332,521,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,293,741,988.42	3,846,122,302.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,293,741,988.42	3,846,122,302.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,201,319,766.07	3,725,553,496.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,047,242,973.56	2,409,664,786.55
210101	Үндсэн цалин	1,287,098,227.18	1,449,163,218.36
210102	Нэмэгдэл	649,917,646.38	784,340,068.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	68,340,000.00
210104	Урамшуулал	110,227,100.00	107,821,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,170,509.98	297,296,524.30
210201	Тэтгэврийн даатгал	175,586,452.82	206,190,346.76
210202	Тэтгэмжийн даатгал	20,657,229.86	24,257,687.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,285,714.87	12,116,963.83
210204	Ажилгүйдлийн даатгал	9,328,222.45	10,952,305.08
210205	Эрүүл мэндийн даатгал	37,312,889.98	43,779,220.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	399,239,097.65	390,303,683.78
210301	Гэрэл, цахилгаан	8,910,575.92	10,725,586.25
210302	Түлш, халаалт	387,515,421.73	376,635,597.53
210303	Цэвэр, бохир ус	2,813,100.00	2,942,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,014,150.00	17,270,700.00
210401	Бичиг хэрэг	668,400.00	3,127,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,077,150.00	2,768,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,268,600.00	11,375,200.00
2105	Нормативт зардал	202,353,560.00	297,560,110.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	542,880.00	00.00
210502	Хоол, хүнс	201,050,680.00	288,040,110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,000.00	9,520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,000,000.00	26,498,500.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	26,498,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,896,000.00	2,591,000.00
210702	Дотоод албан томилолт	2,896,000.00	2,591,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,548,813.97	42,888,867.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,476,500.00	5,849,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	806,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,669,113.97	36,232,867.67



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,854,660.91	241,479,324.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,929,000.00	14,288,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,710,824.00	14,338,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	204,214,836.91	212,853,024.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,422,222.35	120,568,805.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,224,720.00	120,261,090.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,030,820.00	120,261,090.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,193,900.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,197,502.35	307,715.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,197,502.35	307,715.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	102,463,726.58	-322,935,627.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	102,463,726.58	-322,935,627.02

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,269,047,400.00	3,397,342,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	697,200.00	4,209,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	697,200.00	4,209,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	697,200.00	4,209,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	697,200.00	4,209,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,268,350,200.00	3,393,132,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,865,163,600.00	3,060,372,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,865,163,600.00	3,060,372,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	239,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	239,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	403,186,600.00	332,521,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	403,186,600.00	332,521,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,073,885,447.51	3,542,985,968.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,073,885,447.51	3,542,985,968.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,981,463,225.16	3,422,417,162.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,047,242,973.56	2,409,664,786.55
210101	Үндсэн цалин	1,287,098,227.18	1,417,289,233.36
210102	Нэмэгдэл	649,917,646.38	803,525,853.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	68,340,000.00
210104	Урамшуулал	110,227,100.00	120,509,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,170,509.98	297,296,524.30
210201	Тэтгэврийн даатгал	175,586,452.82	206,190,346.76
210202	Тэтгэмжийн даатгал	20,657,229.86	24,255,687.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,285,714.87	12,116,963.83
210204	Ажилгүйдлийн даатгал	9,328,222.45	10,952,305.08
210205	Эрүүл мэндийн даатгал	37,312,889.98	43,781,220.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	397,989,097.65	317,714,784.40
210301	Гэрэл, цахилгаан	8,910,575.92	10,725,586.25
210302	Түлш, халаалт	386,265,421.73	304,404,198.15
210303	Цэвэр, бохир ус	2,813,100.00	2,585,000.00
2105	Нормативт зардал	200,958,600.00	286,859,000.00
210502	Хоол, хүнс	200,958,600.00	286,859,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	14,498,500.00

210604	Урсгал засвар	3,000,000.00	14,498,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,047,613.97	40,392,467.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,378,500.00	4,209,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,669,113.97	36,182,867.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,054,430.00	55,991,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,495,730.00	42,343,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,558,700.00	13,647,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,422,222.35	120,568,805.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,224,720.00	120,261,090.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,030,820.00	120,261,090.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,193,900.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,197,502.35	307,715.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,197,502.35	307,715.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	195,161,952.49	-145,643,668.52
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	71,541,000.00	34,133,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,541,000.00	34,133,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	71,541,000.00	34,133,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,541,000.00	34,133,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-71,541,000.00	-34,133,100.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	123,620,952.49	-179,776,768.52
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	210,123,934.06	333,744,886.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333,744,886.55	153,968,118.03

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,324,344,348.50	00.00	5,446,525,727.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,324,344,348.50	00.00	5,446,525,727.53
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	84,507,200.69	00.00	84,507,200.69




C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,511,315,275.77	00.00	5,633,496,654.80
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,511,315,275.77	00.00	5,633,496,654.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,511,315,275.77	00.00	5,633,496,654.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-322,935,627.02	00.00	-322,935,627.02
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,188,379,648.75	00.00	5,310,561,027.78

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,503,444,600.00	3,244,598,068.52	258,846,531.48	92.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,503,444,600.00	3,244,598,068.52	258,846,531.48	92.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,378,659,800.00	3,124,336,978.52	254,322,821.48	92.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,608,564,500.00	2,409,664,786.55	198,899,713.45	92.4%
210101	Үндсэн цалин	1,616,799,600.00	1,417,289,233.36	199,510,366.64	87.7%
210102	Нэмэгдэл	907,956,300.00	803,525,853.19	104,430,446.81	88.5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	68,340,000.00	-68,340,000.00	
210104	Урамшуулал	83,808,600.00	120,509,700.00	-36,701,100.00	143.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,070,600.00	297,296,524.30	28,774,075.70	91.2%
210201	Тэтгэврийн даатгал	221,728,000.00	206,190,346.76	15,537,653.24	93.0%
210202	Тэтгэмжийн даатгал	26,085,700.00	24,255,687.83	1,830,012.17	93.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,042,800.00	12,116,963.83	925,836.17	92.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	13,042,800.00	10,952,305.08	2,090,494.92	84.0%



210205	Эрүүл мэндийн даатгал	52,171,300.00	43,781,220.80	8,390,079.20	83.9%
2105	Нормативт зардал	290,296,500.00	286,859,000.00	3,437,500.00	98.8%
210502	Хоол, хүнс	290,296,500.00	286,859,000.00	3,437,500.00	98.8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,820,500.00	40,392,467.67	1,428,032.33	96.6%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,859,400.00	4,209,600.00	649,800.00	86.6%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,961,100.00	36,182,867.67	778,232.33	97.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111907700.00	90,124,200.00	21,783,500.00	80.5%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,193,600.00	76,476,700.00	21,716,900.00	77.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,714,100.00	13,647,500.00	66,600.00	99.5%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124784800.00	120,261,090.00	4,523,710.00	96.4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,784,800.00	120,261,090.00	4,523,710.00	96.4%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	124,784,800.00	120,261,090.00	4,523,710.00	96.4%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,503,444,600.00	3,064,821,300.00	438,623,300.00	87.5%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,503,444,600.00	3,060,372,200.00	443,072,400.00	87.4%
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,494,875,200.00	3,060,372,200.00	434,503,000.00	87.6%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,569,400.00	4,449,100.00	2,120,300.00	67.7%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,859,400.00	4,209,600.00	649,800.00	86.6%
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,710,000.00	239,500.00	1,470,500.00	14.0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	333,744,886.55	333,744,886.55	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	153,968,118.03	153,968,118.03	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	84.00	84.00	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	04.00	04.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	53.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,521,000.00	332,213,284.40	307,715.60	99.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,521,000.00	332,213,284.40	307,715.60	99.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,521,000.00	332,213,284.40	307,715.60	99.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,021,000.00	317,714,784.40	306,215.60	99.9%
210301	Гэрэл, цахилгаан	18,586,100.00	10,725,586.25	7,860,513.75	57.7%
210302	Түлш, халаалт	294,484,900.00	304,404,198.15	-9,919,298.15	103.4%
210303	Цэвэр, бохир ус	4,950,000.00	2,585,000.00	2,365,000.00	52.2%



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,500,000.00	14,498,500.00	1,500.00	100%
210604	Урсгал засвар	14,500,000.00	14,498,500.00	1,500.00	100%
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	332,521,000.00	332,626,000.00	105,000.00	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	332,521,000.00	332,521,000.00		100%
132001	Орон нутгийн төсвөөс	332,521,000.00	332,521,000.00		100%
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		105,000.00	-105,000	
	Үйл ажиллагааны орлогоос санхүүжих		105,000.00	-105,000	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган ажиллаж, 2025-2026 оны хичээлийн жилд “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, сурагчдыг бие даан сурах арга барилд сургаж, чадваржуулахад хамтын ажиллагааг чиглүүлнэ” зорилгын дор 16 зорилт дэвшүүлэн сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.


3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын



12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,743.9 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	333,744.9	153,968.1	-179,776.8
Авлага	6,400.0	0.00	-6,400.0
Бараа материал	192,006.3	203,174.5	11,168.2
Үндсэн хөрөнгө	5,101,345.5	5,026,007.3	-75,338.2
Нийт хөрөнгө	5,633,496.7	5,383,149.9	-250,346.8
Өр төлбөр	0.0	72,588.9	72,588.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,633,496.7	5,310,561.0	-322,935.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,633,496.7	5,383,149.9	-250,346.8

Өмнөх оны Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь 2024 онд 333,744.9 мянган төгрөг байсан бол 2025 онд 153,968.1 мянган төгрөг болж буурсан байна.

Авлага данс 6,400.0 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах бараа материалын авлага тайланд онд барагдсан байна.



Бараа материалын дансны үлдэгдэл 203,174.5 мянган төгрөг болж 11,168.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материал өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 5,026,007.3 мянган төгрөг болж 75,338.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 34,133.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 103,381.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 212,853.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 164,538.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 72,588.9 мянган төгрөг болж өссөн нь түлш халаалтын өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,310,561.0 мянган төгрөг болж 322,935.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,850,836.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 400,375.3 мянган төгрөгөөр тоохон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 312,973.6 мянган төгрөгөөр өсгөж, улсын төсвөөс 3,163,810.1 мянга, орон нутгийн төсвөөс 400,375.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 339,555.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,060,451.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 332,521.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,098.9 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,060,372.2 мянга, орон нутгийн төсвөөс 332,521.0 мянга, үйл ажиллагааны орлого 4,449.1 мянга, нийт 3,397,342.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, батлагдсан төсвөөс 436,503.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,244,598.1 мянган төгрөг буюу 92.6 хувьтай байна. Тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 307.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдлээс 179,776.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	3,688.4	3,660.0	28.4	99.2%
2	Хүүхэд хамгаалал /80233/	7,126.4	2,628.0	4,498.4	36.9%
3	Сургалт семинар /80312/	3,488.3	1,975.0	1,513.3	56.6%
4	Эрүүл мэндийг дэмжих /81605/	4,037.9	2,470.0	1,567.9	61.2%
5	Үдийн цай хөтөлбөр	124,784.8	120,261.1	4,523.7	96.4%
6	Дотуур байрны үйлчилгээ /81806/	806,638.1	670,525.1	136,113.0	83.1%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	35,320.3	34,133.1	1,187.2	96.6%



8	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх/81823/	18,199.0	7,035.0	11,164	38.7%
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/	44,728.5	31,146.1	13,582.4	69.6%
10	Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагаа /81834/	2,355,980.8	2,277,638.7	78342.1	96.7%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	80,636.9	77,441.0	3,195.9	96.0%
12	Сурах бичгийн түрээс /81848/	4,859.4	4,209.6	649.8	86.6%
13	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/	12,245.8	11,475.4	770.4	93.7%
14	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	1,710.0	0	1,710.0	0%
15	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	332,521.0	332,521.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

Программын судалгааг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/				
Д/Д	Программ, лиценз нийлүүлсэн байгууллагын нэр	Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/	Зориулалт	Тайланд онд гэрээний дагуу төлсөн төлбөр
1	Санхүүгийн тооцоолох групп	тийм	Архив, бичиг хэрэг	572.0
2	Дижитал ЭДҮ менежмент	үгүй	Санхүү	10,252.0
3	Ай И Ди Си	үгүй	Сургалт	3,399.0
4	БЕГ лицензийн төлбөр	үгүй	сургалт	4,556.4
Нийт дүн				18,779.4

Унаа, хоол, сургалт семинарын орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/					
№	Үзүүлэлт	Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Унаа, хоолны зардал	0.00	68,340.0	-68,340.0	Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 дүгээр албан бичгийн дагуу хоолны зардлыг 5000 төгрөгөөр тооцоон олгож эхэлсэн.
2	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	3,488.3	1,975.0	1,513.3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусадсаны дагуу багшийн хөгжлийн зардлаас багш нарыг 3 удаагийн сургалтад хамруулсан байна.

3	Гадаад томилолт, арга хэмжээ	0.00	0.00	0.00	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
4	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.00	0.00	0.00	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
5	Орон тоо	84	84	0.00	Бүтэц орон тоонд өөрчлөлт ороогүй байна.
7	Хэвлэл мэдээлэл	0.00	0.00	0.00	Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 318,021.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 14,500.0 мянган төгрөгийг төсөвлөн гүйцэтгэлээр 332,213.3 мянган төгрөгийг зарцуулж, 307.7 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотуур байр, үдийн хоолны 2 багц тендер худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд: Хүүхдийн үдийн хоолны материал нийлүүлэх 148,039.1 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоол 345,295.2 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулан шалгарсан компанитай гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,293,742.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 32,937.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,846,122.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 38,461.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 30,769.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн гудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт


Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 175, хугацаа хоцроон байршуулсан 2, мэдээлээгүй 1, мэдээлэх хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.



4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 735.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 38 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	735.5	1	735.5	100%
Нийт дүн	1	735.5	1	735.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

